

О.СҮНДҮЙ

АЙМААР ТОМ НОХОГ  
БҮЮУ  
НАРГИАНТАЙ ШУЛГУУДА





АЙМААР ТОМ НОХОЙ  
БУЮ  
НАРГИАНТАЙ ШУЛГҮҮД



Улаанбаатар  
2007 он

## *Гарчиг*

Аймаар том нохой.....	3
Аав хүү хоёр.....	5
Сурлагын дэвтэр.....	6
Ховч.....	8
Хоосон толгой.....	8
Зураач охин.....	9
Гарны тухай анхны шүлэг .....	9
Суудал солих өдөр.....	10
Огт тоомооргүй яриа .....	11
Бодол.....	12
Халаасанд чихэр байна .....	13
Томчуудын хэлдэггүй үг.....	14
Миний наиз (гүннүүдийн аяз) .....	15
Алиалагч нь хэн бэ? .....	16
Марзан шовгор малгай.....	17
Навчханд өргөх дуу .....	18
Анхны цас .....	18
Намрын үлгэр .....	19
Ягаахан үүд .....	20



## Аймаар том нохой

Арвын хувин хоёрыг барнад  
Өглоо би усанд явсан юм.  
Ангийн хүүхдүүд замд тааралдаад  
Үд болтол тоглосон юм.  
Харин одоо ус байтугай  
Хангир жингэр хувин минь ч алга.  
Тоглосоор суугаад алдаа биз гэж  
Том баагагүй л хэлэх байх даа.  
Үгүй дээ үгүй, тийм биш  
Үнэхээр сүртэй явдал болсоон.  
Усаа аваад ирж явтал  
Урамтай сайхан алхаж байтал  
Аймаар том нохой

Архирч над уруу дайрлаа шүү.  
Аавын хүү аргатай  
Арвын хувинтай усаа  
Ам уруу нь би хийчихлээ.  
Хосгүй том нохойны  
Хоолойд нь ер торсонгүй.  
Хүп хийтэл залгичхаад  
Хоож араас дайрлаа шүү.  
Үлдсэн хувинтай усаа  
Өдоөс нь бас а шидчихлээ.  
Хоёрын хоёр  
Хувинтай усанц хахаад  
Хойноос минь тэр  
Хоож чадсангүй.  
Тэмээ шиг том нохой  
Тэрий хадаад унаалаа.

Болсон явдлыг овоодоо яривал  
Боролдой хүүдээ итгэх болов уу.  
“Ээ дээ, энэ худалч золиг” гээд  
Эмээ минь намайг зэмлэх болов уу.





## *Аав хүү хоёр*

**Аав аа би оноодор  
Авдар дээрээс унаачихсан  
Тэгээд миний хүү яв?  
Тэнгэр доргитол орилов уу?  
Үгүй үгүй, би уйлаагүй  
Өроонд хэн ч байгаагүй.**



## Сурлагын дэвтэр

Ходооноос овоо ирэх гээд байдаг.  
Хүндхэн асуулт тулгараад байдаг.  
Сурлагын дэвтэр маань гурван муутай.  
Сул дүн! Сул дүн! Та нарыг би яая даа.

Харин овоодоо л үзүүлж болохгүй.  
Хаячихсан гэвэл бас үнэмшихгүй.  
Хөөтэй энэ сурлагын дэвтрээс болж  
Ходоо явах, морь унах минь онгорох нь ээ!

Мандах нарнаас орой болтол бодлоо.  
Маргаангүй нэг мэргэн арга оллоо.  
Маргааш найзын минь төрсөн одор  
Манайд ирээрэй гэж намайг урьсан.

Сурлагын дэвтэртээ зураг зураад  
Сугараа найздаа бэлэглэж орхиё.  
Өгсөн бэлгээ буцааж авдагтүй юм гэж  
Өвөө оорое хэлдэг шүү дээ.



$$15 + x = 40$$

## Хөвч

Тогмид очигдөр багш аа!  
Томчуудын кино үзэж байсан.  
Худлаа гэвэл түүний ард  
Хулан бид хоёр сууж байсан.



## Хоосон толгой

Тоогоо бодсон уу?  
Толгойгоо иланэ.  
Томьёогоо цээжилсэн үү?  
Толгойгоо иланэ.

Шүлгээ тогтоосон уу?  
Толгойгоо иланэ.  
Шүүлэгт бэлэн үү?  
Толгойгоо иланэ.

Асуулт бүхэнд  
Толгойгоо иланэ.  
Аргадах мэт  
Зөөлон иланэ.

Хоосон толгойг  
Хэчинээн илэвч  
Хоёроос оор  
Дүнгүй л байна.

# Зураач охин

Дэвтэр дүүрэн  
Алтан нар.  
Дэргэд нь бас  
Монгон сар.

Өдор ч юм уу?  
Шоно ч юм уу?  
Үнэхээр соньхон  
Зураг юм даа.

Амгалан дүнснийх  
Шоно ч биш.  
Айлчлан ирэх  
Өдор ч биш.

Бодлоос торсон  
Бүтээл минь гэж  
Болормаа охин  
Харнуулж байна.



## Гарны тухай анхны шүлэг

Гарны тухай анхны шүлгээ  
Гайхам хурдан бичлээ би.  
Дүүгийн алга бяцхан гэж  
Дүүргээ гэвэл амархан гэж  
Жижигхэн алим аваад огоход  
Жигтэйхэн том харагддаг гэж

Аавын гар аварга гэж  
Арван хуруу нь урт гэж  
Ийм л гараар чихэр тосвол  
Эз дээ, мөн сайхан гэж  
Гарны тухай анхны шүлгээ  
Гайхам хурдан бичлээ би.

# *Суудал солих одор*

**Өнөодөр ёстой онцгой одор  
Ор зүрх дөгдлөх одор.  
Шинэ улирал эхлэх одор  
Ширээний наиз солигдох одор**

Түрүүчийн улиралд Балраатай суусан  
Түүн шиг чалчааг хаанаас ч олохгүй.  
Хичээл хийлгэхгүй ярьсаар байгаад  
Хэдэн ч удаа багшид зэмлүүлэв.

**Өмнөх улиралд Ганаатай суусан  
Үг дуугүй томоотой жаал  
Харин тэр ндэмхий хүүхэд  
Халаас нь дандаа геохийгоор дүүрэн.**

**Өнөодөр ёстой онцгой одор  
Үнэнээ багшид хэлчихмээр одор  
Багш минь намайг мэддэг ч болоосой  
Бяцхан зүрхийг минь сонсдог ч болоосой.**

**Одоохон одоохон суудал борчлогдено  
Одхүүтэй л намайг суулгаад огоосэй  
Хамгийн ухаантай, хамгийн хоорхон нь  
Одхүү юм шүү  
Хааяа түүнийг би зүүдэлдэг юм шүү.**



# Огт тоомооргүй яриа

Хэн нэгэн хөвгүүнтэй  
Хичээлдээ хамт ирвэл  
Ангийн анд Ганаатай  
Автобусанд хамт суувал

Үсийн тэр хөвгүүнтэй  
Үг сольж зогсвول  
Тоогоо ойлгоогүй Батад  
Томьёо тайлбарлаж өгвөл

Манай ангийн Шүрээ  
Маш сонин охин шүү  
Олон хөвгүүдтэй үерхдэг  
Оройтвол гэртээ хүргүүлдэг

Ийм а нэгэн яриа  
Сургуулиар нэг тарах юм.  
Ичмээр байлаа ч наад  
Тоомооргүй санагдах юм.

Хөгжилтэй, зоригтой, ухаалаг  
Хөвгүүд ер нь онцгой шүү  
Хамтдаа байхад нэг а фор  
Халуун итгэлээр үргэлж дүүрэн.

Үднийн харанхуй номорсон ч  
Үл бүтэх нэгэн тааралдсан ч  
Ярдаг нохой дайрсан ч  
Явган шуурга иsgэрсэн ч

Охидын дэргэд хөвгүүд  
Омог бардам зоригтой байдаг  
“Эр хүн” гэдэг фор юмаа гэж  
Ийм а үед хэлмээр байдаг.



## Бодол

Хорш айлын эмээ  
Хоорхон цагаан бүжинтэй  
Үенийн жаалууд бид  
Үснийг нь илбэх дуртай.

Хаалга дандаа онголзууллаа гэж  
Харин эмээ аашилна  
Үүдээ түргэн хaa гэж  
Үргэлж биднийг зэмлэнз.

Хаалга үүдээ  
Хадаж орхивол  
Хамаг зочноо  
Гомдоож буцаавал

Хоорхий эмээ даарна гэж  
Хүмүүсийн сэтгэл л халуун гэж  
Эргэцүүлж би боддог юм  
Эмээгнийнд дандаа зочилдог юм.



## Халаасанд чихэр байна

Хэдэн чихэр  
Халаасанд байна.  
Хэнтэй ч хуваалцахыг  
Хүсэхгүй байна.  
Гаргаад идчихье гэхээр  
Ганцаараа хүлхье гэхээр  
Ангийн нохөд харчихна  
Ах эгч нар мэдчихиэ.  
Бүтэн чихэр минь тал болно  
Бүх чихэр минь алга болно  
Хүн амьтангүй цол газар  
Хүрч очоод идчихье гэж  
Аргагүй би бодлоо  
Али замд гарлаа.  
Хань ноходгүйгээр  
Алсыг зорих нь  
Хамгаас аймшигтайг  
Сая л мэдлээ.





## Томчуудын хэлдэггүй уг

Инээд баясал  
Бялхаж байхад  
Эр зориг  
Оргилж байхад  
  
Баяр хоорроо  
Хувааж байхад  
Бас нэгнийгээ  
Аргадаж байхад  
  
Хоорсон бомбог  
Хаалгаар ороход  
Хоорхон охинд  
Тоогдож байхад  
  
Цонх бүхнээр  
Эзж аавууд  
Зог тусмаар  
Чанга дуугаар  
  
Орой боллоо  
Гэртээ орцгоо!  
Одоо боллоо  
Арай хэтэрлээ!  
  
Хичээлээ хий!  
Хэрвээ болихгүй бол...  
Чирээд оруулъя!  
Чихгүй толгойнууда...  
  
Ауу дуугаа авалцаан  
Дуудах юм.  
Үг хэлээ нийлүүлэн  
Үглэх юм.

“Сайхан нохөрлө хүүхдүүд зэ!  
Санаа сэтгэлээ ойлго” гэж  
Томчууд ердөө хэлэхгүй юм  
Тоглохын учрыг ойлгохгүй юм.

## Миний наиз

(гүннигийн аяз)

Миний наиз  
Энхрийлэх ээжгүй.  
Ээж нь  
Зуурхан жаргалынхаа хорыг амсаад  
Зугаа цэнгэллийнхээ далайд живсэн.

Миний наиз  
Эвнийлэх авагүй.  
Аав нь  
Холчүүрэхээс оор хүслэн үгүй  
Хондүүрлэх элэггүй чулуу юм.

Миний наиз  
Ээнэгших гэргүй.  
Оромж нь  
Нохой ч хоноглож болох хэвтэр юм  
Ноёдын нүдэнд торохгүй хонгил юм.

Миний наиз  
Идэх хоолгүй  
Хоол нь  
Хайрсан хуушуур шиг сонсогдох  
Хатсан навчны шуугнан юм.

Гэхдээ чи миний наиз шүү!  
Гэрэлт орчлонд хамтдаа  
хүүхэд болж ирсэн юм шүү!  
Хүссэн ч хүсээгүй нэг одор  
Хүний орчлонг цутгаа үүрч алхална.





## Алиалагч нь хэн бэ?

Хүмүүсийг алиалагч элэглээд  
Хогжилтэй хооротай инээнэ.  
Алиалагчийг хүмүүс шоолоод  
Адтай цовоо инээнэ.

# Марзан шовгор малгай

Гэрлийн шон шиг ондөр оройтой  
Гэрийн буурь шиг дэrvэгэр хүрээтэй  
Од мичдийн зураг чимэглэлтэй  
Онцгой содон малгайтай байлаа.  
Манай ангийнхан миний малгайг  
“Марзан шовгор” гэдэг байлаа.  
Хүүхэд бүхэн омсож үзээд  
Хоор баяр болдог байлаа.  
Харамсалтай нь гэвэл энэ малгайгаа  
Удаан омсож чадаагүй юм.  
Хавирган сартай зуны үдэш  
Ийм явдал болсон юм.

Аавын онгоцонд суугаад  
Аасар ондорт хоорч явлаа.  
Онгоцын цонхиор толгойгоо цухуйлгаад  
Оддын дундуур нисч явлаа.  
Хавирган сарапд малгай минь олгогдоод  
Харин би толгой нүцгэн хоцорлоо.  
Онгоцын цонхыг хаачхаад  
Очинж аавдаа хэллээ.  
Аав ер тоосонгүй ниссээр  
Агаар зүсэн ниссээр  
Алтан нар мандаж өглөө боллоо.  
Нэг а мэдэхэд онгоц доошилж  
Нислэгийн талбайд зоолон газардлаа.  
Орой нь тэгтэл зурагтаар  
Онцгой мэдээ түглээ.  
Огторгуйн гүнээс нэг малгай  
Од шиг харваад унасан гэнэ.  
Малчин айлын гэрэлтэй цонхиор  
Манас хийтэл буусан гэнэ.  
Маш сонин хийцтэй  
Марзан шовгор малгайг  
Харь гарагийнхны малгай гэж  
Нэг хэсэг таамаглажээ.  
Хаанаас даа, энэ чинь бурхны малгай гэж  
Ногоо хэд нь маргажээ.





## Навчанд өргөх дүү

Өмнөөс дүү минь инээх шиг  
Ногоохон нахна дэлгэрнэ.

Өожкин ходолгогх ижийн шиг  
Алтан улиас ганхана.

Охоордин охоордин энхрийлж  
Борхон шувууд жиргэнэ.

Осоорэй осоорэй навчхан минь  
Сорийн дуугаа дуулаарай.

## Анхны цас

Цайран буух цасны  
Ширхэг бүхэн дээр  
Цав цагаахан охид суусаар  
Энэхэн дэлхийд ирнэ.

Эргээд а тэд  
Нарны цацраг дамжини буухдаа  
“Эхний цасыг авчирлаа” гэж  
Инээмсэглэсээр одоцгооно.



## Намрын улгэр

Үүлс мөлхсон  
Намрын одор  
Өвгөн буурай  
Хүс мод

Оддын садан  
Алтан наранд  
Орь ганицхан  
Мороодлөө задалж

“Мөнх нас  
Хайрлаач” гэж  
Мочир бүхнээсээ  
Алт дэлгэжээ.

Буцаж яваа  
Тэнгэрийн элч  
Буурал хусны  
Хүслийг сонсоод

Алт монгоор  
Арилжаалж болдогтүй  
Амьдралын жамыг  
Үчирлаж гэнэ ээ.

Хоорхий хусны  
Шижир зоосоор  
Хөндийн салхи  
Эрхэлж гэнэ ээ.



## Ягаахан үүл

Тэнгэрийн хаяанд Ягаахан үүл  
Ягаахан үүл  
Тэр юутай Энхрийхэн үүл  
Энхрийхэн үүл

Наран шингэх үлгэрийн хязгаарт  
Намуухан ягаахан бороо орно уу?  
Цэцэг цэцгийн дэлбээнд  
Ягаахан шүүдэр бонжийгоод  
Цэн цэн дуслаар нь  
Ямхан охин эрхэлнэ үү?

Аль эсвэл тэнд ягаахан цас бударна уу?  
Алимны боөр шиг улаахан хацартай жаалууд  
Атга атгаар нь  
Ягаахан цас шидэлж  
Аихны од түгтэл  
Гэртээ оролгүй наадна уу?

Ай цэнхэрхэн үдшийн  
Ягаахан үүл, ягаахан үүл  
Цэмцийсэн бумбайсан  
Энхрийхэн үүл, энхрийхэн үүл



# тиний ОД

Хүн бүхэнд оорийн од бий  
Хүүхэд ч гэсэн надад од бий  
Тэр нэгэн эгэлхэн одыг  
Тэртээд гялалзах тодхон одыг  
Оорийн од болгож зүсэлсэн юм  
Үй түмэн оддоос сонгосон юм  
Тэр миний од  
Тэнгэрт орших гэрэл гэгээ.  
Сайхан сэтгэлээр найздаа  
тусалсан одор  
Саруулхан од минь улам  
гэрэлтэй харагдана  
Хэн нэгэнд гомдолж гүнихад  
Цэн од минь бүүдгэр үзэгдэнэ.

Од бүхэн гэрлээ хүмүүссээс  
авдаг байх  
Олон сайхан хүмүүс байдаг  
боловоор  
Тэгж гэрэлтдэг байх  
Тэнгэр дүүрэн мишээдэг байх  
Оорийн ОД-оо гэрэлтэй  
байлгах гэж  
Очноон сайхан үйлс би бүтээнэ  
Од минь чи надад итгэрэй  
Орчлонг бүтэн байлгах гэж  
Торсон юм шүү би.



## Оюунбадамын СҮНДҮЙ Аймаар том нохой буюу наргиантай шүлгүүд

Зураач: П.Оюунцэцэг  
Хянан тохиолдуулсан:  
Ж.Гэрэлмаа  
Эх бэлтгэсэн: Д.Хишигдэлгэр

INTERPRESS<sup>®</sup>

Хэвлэн нийтлэлийг  
Интерпресс ХХК



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хурээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.